



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06-р сарын 14 өдөр

Дугаар А/300

Арвайхээр

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг, Залуучууд 1-114 тоотод байрлах “Өв гурван лут” ХХК-ийн “The Grand villa” хотхны С блокын 20 айлын нийтийн орон сууцны барилга, байгууламжийн угсралтын ажил дуусаж байгаа тул “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу дунд төвөгшилтэй барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”, гурвалсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0641

Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 08-ны өдрийн
.....дугаар захирамжийн
хавсралт

**ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Т.Ариунболд (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Г.Түвшинтөр (аймгийн Ерөнхий архитектор)

С.Нямдорж (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Г.Балжинням (аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

С.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Г.Ганбаатар (Зураг төслийн "Шифт" ХХК-ийн захирал)

Б.Даваадагва ("Онги ус суваг" ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)

Ц.Оюунтунгалаг (Өвөрхангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн)

М.Багаажав (ЭБЦТС ТӨХК"-ийн ӨВ дахь салбарын Ашиглалтын инженер)

Н.Буянзул ("МХС" ТӨХК-ийн ӨВ аймаг дахь салбарын Ахлах инженер)

Б.Эрдэнэбаяр("МЦХ" ТӨХК-ийн ӨВ аймаг дахь салбарын Ахлах инженер)

Т.Мөнхбаян (Арвайхээр сумын Захирагчийн албаны Архитектор)

Э.Мөнхбаатар (Арвайхээр "Онги өргөө" СӨХ-ийн гүйцэтгэх Захирал)

Гүйцэтгэгч: Б.Баярбат ("Өв гурван лут" ХХК-ийн захирал)

Б.Чулуунбадрах ("Тулгуурт Оргил" ХХК-ийн захирал)

Ц.Мөнхзориг ("Мөнх Хүчдэл" ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: С.Мөнхзаяа (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын мэргэжилтэн)

Б.Баярмаа (Өв гурван лут" ХХК-ийн нягтлан бодогч)